210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,266,700.00	35,266,700.00	39,712,800.00	39,625,677.00
2105	Нормативт зардал	259,729,400.00	163,736,548.00	165,901,400.00	150,466,790.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,083,400.00	40,630,388.00	56,012,700.00	44,004,303.00
210502	Хоол, хүнс	194,136,900.00	109,600,160.00	102,775,600.00	99,349,387.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,509,100.00	13,506,000.00	7,113,100.00	7,113,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,096,500.00	48,591,700.00	65,641,400.00	65,619,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,813,300.00	13,813,300.00	27,293,300.00	27,293,300.00
210602	Тавилга	9,440,000.00	9,440,000.00	529,700.00	529,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	800,000.00		
210604	Урсгал засвар	30,043,200.00	24,538,400.00	37,818,400.00	37,796,700.00
2107	Томиллолт, зочны зардал	12,618,300.00	8,139,430.00	7,258,200.00	5,780,350.00
210702	Дотоод албан томилолт	12,618,300.00	8,139,430.00	7,258,200.00	5,780,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,168,600.00	94,517,014.00	15,884,300.00	14,626,977.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,574,400.00	81,832,150.00	9,143,100.00	8,938,368.00

Хужирт сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,988,000.00	2,604,000.00	2,142,600.00	1,419,028.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,339,400.00	1,192,164.00	1,180,000.00	1,180,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	821,000.00	765,700.00	414,200.00	161,350.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195,000.00	173,000.00	93,800.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,570,000.00	5,570,000.00	217,300.00	216,431.00
210807	Газрын төлбөр	2,680,800.00	2,380,000.00	2,693,300.00	2,689,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	93,134,400.00	89,376,457.00	270,441,500.00	237,215,610.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,544,300.00	71,791,657.00	254,123,600.00	220,918,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,590,100.00	17,584,800.00	16,317,900.00	16,297,550.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,519,300.00	47,431,900.00	82,889,500.00	78,872,030.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,519,300.00	47,431,900.00	82,889,500.00	78,872,030.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,449,300.00	38,142,900.00	71,118,500.00	67,118,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,070,000.00	9,289,000.00	11,771,000.00	11,753,530.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199,853,800.00	143,416,900.00	286,319,300.00	231,773,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	199,853,800.00	143,416,900.00	286,319,300.00	231,773,000.00
223001	Бусад хөрөнгө	199,853,800.00	143,416,900.00	286,319,300.00	231,773,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	99,356,600.00	21,750.00	202,453,100.00	105,200,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	99,356,600.00	21,750.00	202,453,100.00	105,200,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,719,059,800.00	4,575,282,482.19	5,052,415,200.00	4,836,628,428.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,078,900,500.00	3,006,639,105.00	3,086,232,200.00	3,086,232,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,078,900,500.00	3,006,639,105.00	3,086,232,200.00	3,086,232,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,206,509,500.00	1,382,287,675.19	1,411,510,100.00	1,563,162,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	1,099,165,000.00	1,274,943,175.19	1,270,519,600.00	1,422,172,100.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	107,344,500.00	107,344,500.00	140,990,500.00	140,990,500.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,264,300.00	55,066,292.00	68,264,500.00	53,771,490.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	68,264,300.00	55,066,292.00	68,264,500.00	53,771,490.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	365,385,500.00	131,289,410.00	486,408,400.00	133,461,838.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,113,200.00	118,169,410.00	103,511,200.00	125,695,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,600,000.00	620,000.00	35,600,000.00	7,766,138.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	282,672,300.00	12,500,000.00	347,297,200.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	59,206,521.00	-	199,785,824.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	199,785,824.00	-	184,460,702.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	157,556,083.00	651,947,392.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	116,556,083.00	458,947,392.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	116,556,083.00	412,997,392.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,812,500.00	60,817,520.00
210101	Үндсэн цалин	2,812,500.00	59,065,456.97
210102	Нэмэгдэл	-	1,752,063.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	5,553,281.00
210201	Тэтгэврийн даатгал	-	3,822,873.38
210202	Тэтгэмжийн даатгал	-	438,083.84
210203	ҮОМЦЮ-ний даатгал	-	666,418.68
210204	Ажилгүйдлийн даатгал	-	85,623.62
210205	Эрүүл мэндийн даатгал	-	540,281.48
2104	Хангамж, бараа материалын зардал	40,902,570.00	27,019,830.00
210401	Бичиг хэрэг	683,200.00	2,014,415.00
210402	Тээвэр, шатахуун	5,331,360.00	9,962,546.00
210404	Ном, хэвлэл	5,821,210.00	5,330,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		298,967.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,066,800.00	9,412,952.00
2105	Нормативт зардал	-	141,553,164.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	132,966,551.00
210502	Хоол, хүнс	-	8,586,613.00
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	24,605,000.00	1,032,066.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,605,000.00	1,032,066.00
2107	Томилолт, зочны зардал	705,000.00	856,000.00
210702	Дотоод албан томилолт	705,000.00	856,000.00

Хужирт сумын төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,444,740.00	128,220,688.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,444,740.00	128,220,688.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,086,273.00	47,944,843.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,086,273.00	47,944,843.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	44,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	44,600,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		44,600,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,000.00	1,350,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	1,350,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,900,000.00	193,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	40,900,000.00	193,000,000.00
223001	Бусад хөрөнгө	40,900,000.00	193,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	157,556,083.00	651,947,392.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	157,556,083.00	651,947,392.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,406,800.00	316,872,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	84,919,283.00	329,744,242.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	230,000.00	5,330,950.00

3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хужирт сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.21-ээс 2022.03.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.03.21-ний өдрийн 1/29 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 9 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс, 1 баг, 1 ТӨҮГ нийт 15 тайлан нэгтгэгджээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно” гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хужирт сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хужирт сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 8107.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 81.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 64.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 308.0 сая төгрөгөөр өссөн байна.

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	523.9	831.9
31211	Төрийн сангийн харилцах	523.9	831.9

Дараах байгууллагуудын данс мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

- Эрүүл мэндийн төв – 0.9 сая төгрөг
- Сум хөгжүүлэх сан – 119.4 сая төгрөг
- Эрсдэлээс хамгаалах сан – 9.6 сая төгрөг
- Орон нутгийн хөгжлийн сан – 54.5 сая төгрөг
- Хужирт-Эрдэс баялаг – 18.3 сая төгрөг
- Орон нутгийн ерөнхий орлого – 629.2 сая төгрөг

3.5.2 Авлага

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
33	АВЛАГА	370.9	472.2	101.3
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.8	0.1	(0.7)
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4.2	129.8	125.6
33400	Зээлийн хүүгийн авлага	7.1	4.0	(3.1)
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	-	0.3	0.3
33510	Байгууллагаас авах авлага	9.5	1.8	(7.7)
33520	Хувь хүмүүсээс авах авлага	349.3	336.2	(13.1)

Тайлант онд нийт авлага 101.3 сая төгрөгөөр өссөн байна. Татаас санхүүжилтийн авлага нь ЭМТ-ийн ЭМД-аас авах авлага байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 64.2 сая төгрөгөөр өссөн байна.

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
35	БАРАА МАТЕРИАЛ	515.2	579.4	64.2
351	Түүхий эд материал	352.8	390.8	38.0
35300	Бэлэн бүтээгдэхүүн	8.7	8.4	(0.3)
354	Хангамжийн материал	112.9	138.9	26.0
35600	Мал амьтад	40.8	41.3	0.5

Тайлант онд бараа материал ЭМТөв 39.2 сая төгрөг, ЕБС 2.8 сая төгрөг, 1-р цэцэрлэг 4.7 сая төгрөг, 2-р цэцэрлэг 4.8 сая төгрөг, 3-р цэцэрлэг 10.6 сая төгрөг, 4-р цэцэрлэг 20.8 сая төгрөгөөр тус тус өсөж, ЗДТГ 6.0 сая төгрөг, ИТХ 2.4 сая төгрөг, Соёлын төв 10.3 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 598.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хужирт сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 1254.8 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 319.7 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 69.4 сая төгрөг дахин үнэлгээний нэмэгдэл, 865.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 94.0 сая төгрөгийн

хөрөнгийг акталж, 464.4 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн, 97.7 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлгээний хорогдлоор тус тус данснаас хассан байна.

№	Үзүүлэлт	Хөрөнгийн дүн
1	Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	11,564.0
2	Нэмэгдсэн	1,254.8
201	Худалдан авсан	319.7
202	Хандиваар	95.9
203	Шилжүүлэн авсан	455.1
205	Бусад	314.7
206	Дахин үнэлгээний нэмэгдэл	69.4
3	Хасагдсан	656.1
302	Акталсан	94.0
303	Шилжүүлсэн	464.4
306	Дахин үнэлгээний хорогдол	97.7
4	Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,162.7

3.5.5 Өр төлбөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
413	Өглөг	79.8	134.2	54.4
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	35.8	35.8
41361	Байгууллагад төлөх өглөг	77.4	90.0	12.6
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2.1	8.0	5.9
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.3	0.4	0.1

Тайлант онд өр төлбөр 54.4 сая төгрөгөөр өссөн. Нийт өр төлбөрийн 97.2 хувийг ЭМТөвийн өр эзэлж байгаа бөгөөд энэ нь ажилчдын цалинд 35.4 сая төгрөг, хувь хүн болон байгууллагад 17.5 сая төгрөгөөр эм болон бараа материалын өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 8/2/6 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 189.4 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 705.0 сая төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөө 515.6 сая төгрөг буюу 372.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Үйл ажиллагааны орлого/ орлогыг тодорхойлох боломжгүй иргэний ОАТ/	51.2	39.4	(11.8)	77.0%
2	Хөрөнгийн албан татвар / хадгаламж	58.3	77.7	19.4	133.3%
3	Улсын тэмдэгтийн хураамж	2.7	3.8	1.1	140.7%
4	Хог хаягдлын хураамж	23.0	27.8	4.8	120.9%
5	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0.8	3.4	2.6	425.0%
6	газрын төлбөр	18.1	14.1	(4.0)	77.9%
7	Ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	12.5	15.7	3.2	125.6%
8	Бууны албан татвар	2.3	2.4	0.1	104.3%
9	Малын албан татвар	-	73.2	73.2	
10	Хүү, торгуулийн орлого	17.0	35.1	18.1	206.5%
11	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	3.0	29.4	26.4	980.0%
12	Рашаан ус ашигласны төлбөр	0.5	0.8	0.3	160.0%
13	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	-	382.2	382.2	
Нийт орлогын дүн		189.4	705.0	515.6	372.2%

3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 5052.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 3086.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 1411.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 68.3 сая төгрөгийг нийгмийн даатгалын сан, 486.4 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3086.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1563.2 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 53.8 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаа болон санхүүгийн дэмжлэгээр 133.4 сая төгрөг, нийт 4836.6 сая төгрөгийн санхүүжилт, болон орлогын эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 4328.6 сая төгрөг, хөрөнгийн зардалд 231.8 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 105.2 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 78.9 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 651.9 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 413.0 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 45.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 193.0 сая төгрөгийг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хужирт сумын Төрийн сан нь 2021 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 147 мэдээллийг ил тод хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 4.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Хужирт сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 12 байгууллагын 3 байгууллагад дүгнэлт гаргаж, /ЕБС, Хужирт-Эрдэс баялаг ТӨҮГ, 4-р цэцэрлэг/ 9 байгууллагыг түүвэрт хамруулсан /ЗДТГ, ИТХ, ЭМТ, 1-р цэцэрлэг, 2-р цэцэрлэг, 3-р цэцэрлэг, Соёлын төв, ОНХСан, СХСан/

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 1191.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 26.9 сая төгрөгийн алдааг залруулж, 1164.6 сая төгрөгийн 15 албан шаардлага, 0.1 сая төгрөгийн 1 зөвлөмжийг хүргүүлсэн.

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой нийт 13.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн. Үүнд:

ИТХ- Тайлант онд хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 5.6 сая төгрөгийг УБ хотод нутгийн удирдлагын холбоонд сумын ИТХ-ын төлөөлөгчдийг сургалтад хамруулсан сургалт, байр, хоол, унааны зардалд зарцуулсан

ЗДТГ- Засгийн газрын 2021 оны 43 -р тогтоол зөрчиж 0.9 сая төгрөгийн зардал гаргасан

ЕБС- 1.5 сая төгрөгийн нормын хувцас худалдан авсан

1-р цэцэрлэг- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс 1.9 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан.

2-р цэцэрлэг- Төсвийн хөрөнгөөр 3.3 сая төгрөгийн хувцас, тавилга эд хогшил худалдан авсан

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 26.9 сая төгрөгийн алдаа илэрсэн.

1-р цэцэрлэг- Төсвийн санхүүжилтээс төрийн санд буцаан төвлөрүүлсэн 10.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлд оруулж тайлагнасныг залруулсан.

3-р цэцэрлэг- Төсвийн санхүүжилтээс төрийн санд буцаан төвлөрүүлсэн 11.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсвийн гүйцэтгэлд оруулж тайлагнасныг залруулсан.

ЭМТ- Мөнгөн гүйлгээний тайланд 5.0 сая төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгийн зардалд тусад нь тайлагнаагүй. Сэлбэг хэрэгслийн балансын үлдэгдэл тодруулга тайлангийн үлдэгдэл 0.07 сая төгрөгөөр зөрснийг тус тус залруулсан.

- Дотоод хяналт хариуцлагатай холбоотой 119.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

ЕБС- Шатахуун зарцуулалтын 3.0 сая төгрөгийн анхан шатны баримт бүрдүүлээгүй, замын хуудас үйлдэж тооцоо бодоогүй, зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь тодорхойгүй байна.

ЭМТ- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийн үлдэгдэл /барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил/ балансын үлдэгдлээс 59.3 сая төгрөгөөр зөрсөн. Тусгай зориулалтын материалын жилийн эцсийн үлдэгдлээс эд хариуцагчийн тайлангийн үлдэгдэл 43.6 сая төгрөгөөр дутуу, тооллогын бүртгэл нь балансын үлдэгдлээс 13.2 сая төгрөгөөр дутуу, бичиг хэргийн материалын тооллогын бүртгэлийн үлдэгдэл балансын үлдэгдлээс 0.1 сая төгрөгөөр зөрүүтэй, тооллогын тооцоо бодсон акт үйлдээгүй тооллогыг чанаргүй хийсэн. Зөрчлийн дүн 116.3 сая төгрөг

Хужирт-Эрдэс баялаг ТӨҮГ- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж мөрдөөгүй байна. Өмнөх аудитын шаардлагыг биелүүлээгүй

- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 10.6 сая төгрөгийн дараах зөрчил илэрсэн.

1-р цэцэрлэг- Урсгал зардлын төсвөөс 5.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн.

2-р цэцэрлэг- Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас аж ахуйн материал худалдан авсан, цэвэр бохир усны зардлаас тээвэр шатахууны зардал гарсан, Хүүхдийн хоол хүнсний зардлаас ахмадын баярт зориулан гарын бэлэг өгсөн. Нийт зөрчлийн дүн 3.5 сая төгрөг

3-р цэцэрлэг- Урсгал зардлын төсвөөс 1.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн.

4-р цэцэрлэг- Цэвэр, бохир усны зардлаас шатахууны зардалд зориулалт бус зарцуулсан, цалин хөлсийг НДШ-ийн тайланд дутуу тайлагнасан, хүүхдийн хоолны зардлыг нормативаас хэтрүүлэн зарцуулсан. Нийт зөрчлийн дүн 0.7 сая төгрөг

- Нийцлийн аудитаар 1021.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

ЭМТ- Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 41 удаагийн 874.9 сая төгрөгийн гүйлгээ, зарлагын 3 удаагийн 53.0 сая төгрөгийн гүйлгээ тус тус мэдээллээгүй байна. Өмнөх онд албан шаардлага өгч байсан зөрчил дахин давтан гарсан. Зөрчлийн дүн 928.0 сая төгрөг

4-р цэцэрлэг - Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтуудын 28.5 сая төгрөгийн мэдээллийг дутуу мэдээлсэн

Хужирт-Эрдэс баялаг ТӨҮГ- НИК ХХК 15.1 сая төгрөгийн шатахуун худалдан авалтыг өссөн дүнгээр байршуулахаас 10.9 сая төгрөг байршуулан, 4.2 сая төгрөгийг дутуу байршуулсан. Мөн санхүүжилт 62.0 сая төгрөгийг өссөн дүнгээр тус тус шилэн дансанд байршуулаагүй байна. Зөрчлийн дүн 65.1 сая төгрөг

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Хужирт сумын Төрийн сан	0	0	0	00	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Р.ЭНХЗУЛ



2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР